



ДУНДГОВЬ АЙМАГ
ӨЛЗИЙТ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар A/01

Рашаант

“Боловсролын чанар хүртээмжийг сайжруулан,
иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх жил”
болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.3 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 4, 6 дугаар зүйл, Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн A/01 дүгээр захирамж, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Боловсролын үйлчилгээний чанарыг ахиулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх, үйлчилгээ, чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор 2023 оныг “Боловсролын чанар хүртээмжийг сайжруулан, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх жил” болгон зарласугай.
2. “Боловсролын чанар хүртээмжийг сайжруулан, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх жил”-ийн ажлыг орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.
3. “Боловсролын чанар хүртээмжийг сайжруулан, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан сумын иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд идэвх санаачилга, үр бүтээлтэй хамтран ажиллахыг уриалсугай.
4. “Боловсролын чанар хүртээмжийг сайжруулан, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх жил”-ийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, сумын Засаг даргын орлогч (Х.Шинэбаатар), 2023 оны ажлын төлөвлөгөөндөө зорилт, арга хэмжээ тусган шаардагдах зардлын эх үүсвэрийг шийдвэрлэж, ажиллахыг төсвийн шууд захирагч наарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ГАСРАНДОРЖ



Сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны
өдрийн А/01 дүгээр захирамжийн хавсралт



**“БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫГ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАН
ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЖИЛ”-ИЙН
АЖЛЫГ ОРОН НУТАГТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: - Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: - Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: - Санхүүгийн албаны дарга

- Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн
- Ерөнхий боловсролын сургуулийн захирал
- Цэцэрлэгийн эрхлэгч
- Эрүүл мэндийн төвийн дарга
- Соёлын төвийн дарга
- Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
- Хөдөлмөр эрхлэлт, хalamжийн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн
- Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн